



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/525

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган суман дахь Нисэх буудлын 60, Дарви сумын Соёлын төвийн түүхт 80 жилийн ой болон Шүүхийн байгууллага, сум, орон нутгийг хөгжүүлэхэд үйлсэд идэвх зүтгэлтэй ажиллаж буй нэр бүхий иргэдийг нарыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 120000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 120000 төгрөг /Нэг зуун хорин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 13-ны өдрийн
А/525 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Ц.Галбадрах	Булган суман дахь Нисэх буудлын онгоцны техникч	30000
2	Л.Дэлгэрмаа	Дарви сумын Цэцэрлэгийн багш, ардын авъяастан	30000
3	Ш.Далхаасүрэн	Ховд аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах	30000
4	Ш.Тогтмол	Буянт сумын Норжинхайрхан багийн иргэн	30000
Дүн			120000